



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 90

Номгон

Г
Ээлжит бус хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэхь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XYII хуралдааныг 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10:00 цагт Баянхонгор сумын төвд хуралдуулахаар товлон зарлаж, дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1. Боловсрол, эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай
1.2. Улаанбаатар хот дахь Баянхонгор аймгийн нутгийн зөвлөлийн ажиллах журам батлах тухай

1.3. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн мэлмий гийсний 380 жилийн ойг зохион байгуулсан тайлангийн тухай

1.4. Орон нутгийн өмчит ХХК, үйлдвэрүүдийн газруудын үйл ажиллагааны тайлангийн тухай /"Баянхонгор хайрхан фарм" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, "Хонгор шинэ агро" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци"/

2. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар урьдчилан хэлэлцүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.



Ц.ОТГОНБАЯР

1190085
D:/2018/Alban bichig/th togtool-2019